

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.НАЗАРБАЕВЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаярын урилгаар Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Нурсултан Назарбаев 2008 оны 8 дугаар сарын 6-наас 7-ны өдөр Монгол Улсад төрийн айлчлал хийв.

Хоёр улсын төрийн тэргүүн нар (цаашид “Талууд” гэх) Монгол-Казахстаны харилцааны өнөөгийн хөгжлийн явцад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж, хоёр талын хамтын ажиллагаа, түүнчлэн харилцан сонирхсон бүс нутгийн болон дэлхий нийтийг хамарсан өргөн хүрээтэй асуудлыг хэлэлцэв.

Найрамдал, харилцан ашигтай хамтын ажиллагааны үзэл санаагаар харилцаагаа бүх талаар хөгжүүлэх нийтлэг эрмэлзлэлд тулгуурлан Талууд дараахь мэдэгдлийг хийв:

1. Талууд хоёр орны хоорондын уламжлалт найрсаг харилцаагаа Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай 1993 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Гэрээ, Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх тухай 1998 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хамтарсан тунхаглал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн хамтарсан мэдэгдлийн заалтуудад нийцүүлэн бүх талаар өргөжүүлэн хөгжүүлнэ.

2. Улс төрийн идэвхтэй яриа хэлэлцээ явуулж, орчин үеийн тулгамдсан асуудлаар бүс нутгийн болон дэлхий нийтийн хэмжээнд нягт харилцан ажиллах нь хоёр орны хоорондын харилцааг цаашид тогтвортой хөгжүүлэх, харилцан итгэлцлийг улам бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэж Талууд үзэж байна.

3. Талууд хамгийн өргөн хүрээний асуудлаар хоёр талын хамтын ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор хоёр орны засгийн газар, төрийн янз бүрийн байгууллагын хоорондын харилцаа холбоог цаашид бататган идэвхжүүлэх шаардлагатай гэж үзэв.

4. Талууд эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, олон хэлбэр төрөлтэй болгоход онцгой анхаарч, хоёр орны хоорондын худалдааг өргөжүүлэх, тухайлбал бүс нутаг хоорондын харилцаа холбоог хөгжүүлэх замаар өргөжүүлэх сонирхлоо илэрхийлэв. Түүнчлэн Талууд ашигт малтмалын хайгуул, олборлолт, тээвэр, харилцаа холбоо, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, банк зэрэг салбарт хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн төлөө байна.

Энэ зорилгоор Талууд Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны дунд хугацааны хөтөлбөр боловсруулах шаардлагатай гэж үзэв.

Талууд Монгол-Казахстаны шууд хөрөнгө оруулалтын сан байгуулахыг дэмжиж, энэ чиглэлээр нягт харилцан ажиллах нь Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын бизнесийн хүрээн дэх эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээг гүнзгийрүүлэн өргөжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв.

5. Талууд эдийн засгийн салбар дахь хоёр талын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах хэрэгт Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхийн төлөө байна. Талууд Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Бүгд Найрамдах Казахстан Улсын Худалдаа-аж үйлдвэрийн танхимын хооронд Бизнесийн хамтарсан зөвлөл байгуулсныг мөн сайшаан баяр хүргэв.

6. Талууд цэргийн боловсон хүчин бэлтгэх, түүнчлэн цэрэг-техникийн болон энхийг сахиулах олон улсын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлэв. Хоёр орны цэргийн салбар дахь хамтын ажиллагаа нь тэдгээрийн нэгдэн орсон олон улсын бусад гэрээнээс үүсэх Талуудын эрх, үүргийг хөндөхгүй бөгөөд бусад улсын ашиг сонирхол, аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй байдлын эсрэг чиглээгүй болно.

7. Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улс нь хоёр ард түмний уламжлалт түүхэн хийгээд соёлын хэлхээ холбоог бэхжүүлэн баяжуулах шийдвэр төгс байна. Талууд соёл, шинжлэх ухаан, боловсролын салбар, түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, холбоо харилцааг хөхиүлэн дэмжинэ. Талууд хоёр орны ард түмний түүхийн болон соёлын өвийг харилцан судлах, соёлын хамтарсан арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлал, археологийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг бүх талаар дэмжинэ.

Казахстаны тал Монгол Улсад байгаа казах ард түмнийг анхааран халамжилж, угсаатны өвөрмөц ахуй байдал, хэл, соёл, уламжлалаа хадгалахад нь шаардлагатай нөхцлөөр хангаж байдагт нь Монголын талд талархал илэрхийлэв. Талууд Монгол Улсын казах ард түмнийг монголын нийгмийн зохих бүрэлдэхүүн хэсэг хэвээр байлгах сонирхолтой байна.

8. Монгол, Казахстан хоёр улс нь бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны асуудлаар тогтмол зөвлөлдөж, хүчин чармайлтаа байнга уялдуулах нь чухал гэж үзэв. Талууд аюулгүй байдлын асуудлаархи АСЕАН-ы Бүсийн чуулга, Азийн хамтын

ажиллагааны яриа хэлэлцээ болон Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх зөвлөлгөөн (АХАИБЗ) зэрэг бүс нутгийн байгууллагуудын зорилго, зорилтыг бүрэн дэмжиж байна.

9. Талууд Ази тивийн орнуудын хооронд яриа хэлэлцээ өрнүүлэх, итгэлцлийг тогтоон гүнзгийрүүлэх үр дүнтэй механизм болохынх нь хувьд Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх зөвлөлгөөний ач холбогдлыг өндрөөр үнэлэв. Үүнтэй холбогдуулан Монгол Улс АХАИБЗ-ий экологийн салбар дахь итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулагч болох боломжийг судалж үзнэ.

10. Талууд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ) нь бүс нутгийн орнуудын сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгааг онцлон тэмдэглэж, Монгол Улс болон ШХАБ-ын хамтын ажиллагааны хүрээнд эрчим хүч, дэд бүтэц, харилцаа холбоо, тээвэр зэрэг салбарт харилцан ажиллагааг идэвхжүүлэх сонирхлоо илэрхийлэв. Бүгд Найрамдах Казахстан Улс Монгол Улсын энэ чиглэлээр гаргаж буй хүчин чармайлтыг сайшаан дэмжив.

11. Төв Азид цөмийн зэвсгээс ангид бүс байгуулах тухай гэрээнд Төв Азийн таван улсын төлөөлөгчид 2006 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр гарын үсэг зурсанд Монголын тал баяр хүргэж, тийм бүс байгуулсан нь цөмийн зэвсэг хураах, цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх дэглэмийг хамгаалах талаархи олон улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх хэрэгт нааштай алхам болсон бөгөөд бүс нутаг болон дэлхий дахинд бүхэлд нь энх тайван, аюулгүй, тогтвортой байдлыг хангахад бодит хувь нэмэр болж байна гэж үзэж байна.

Үүнтэй уялдуулан Казахстаны тал Монгол Улсын олон улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын эрх зүйн хувьд бататгахад чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын хүчин чармайлтыг дэмжиж байгаагаа нотолж байна.

12. Талууд гишүүн нь болж буй олон улсын болон бүс нутгийн эдийн засгийн байгууллага дахь харилцан ажиллагаагаа улам бэхжүүлнэ. Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэх Бүгд Найрамдах Казахстан Улсын хүсэлтийг Монгол Улс дэмжиж байна.

13. Нийтлэг эрх ашгийн үүднээс Талууд далайд гаршгүй хөгжиж буй орнуудын хувьд олон улсын худалдаанд тулгарч буй бэрхшээлийг даван туулах зорилгоор тэдгээр орны хоорондын хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэх шаардлагатайг тэмдэглэж, Алматын тунхаглал болон Алматын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхийн төлөө байна.

14. Хүрээлэн буй орчныг хамгаалах асуудалд онцгой анхаарч энэ салбарт хамтран ажиллах бүс нутгийн механизмыг бүх талаар бэхжүүлэх нь чухал гэж Талууд үзэж байна. Цаг уурын өөрчлөлтийн

асуудлаархи Зүүн Хойд Азийн улсуудын төрийн тэргүүн нарын уулзалт зохион байгуулах Монгол Улсын санаачлагыг Казахстаны тал бүрэн дэмжиж буйгаа илэрхийлэв.

15. Талууд олон улсын терроризм, шашны хэт даврах үзэл, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт болон түүнтэй адил бодис, прекурсор, зэвсгийн хууль бус наймаа, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, цөмийн материалын хууль бус наймаа, хууль бус шилжилт хөдөлгөөний эсрэг тэмцэлд хоёр талын болон олон улсын холбогдох байгууллагын хүрээнд олон талын түвшинд нягт харилцан ажиллахад бэлэн байгаагаа нотолж байна.

16. Олон улсын тавцанд хоёр орны харилцан ажиллагааг гүнзгийрүүлэхийн чухлыг цохон тэмдэглэхийн хамт Талууд гишүүн нь болсон олон улсын байгууллагуудын хүрээнд хүчин чармайлт, байр сууриа уялдуулан зохицуулна гэдгээ мэдэгдэж байна. Талууд НҮБ-ыг олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүн орнуудын эрх тэгш харилцааг хэрэгжүүлэх, дэлхий дахины тогтвортой, аюулгүй байдлыг бэхжүүлэх түгээмэл хэрэгсэл мөн гэж үзэж уг байгууллагын олон улсын үйл хэрэгт гүйцэтгэх үүргийг бэхжүүлэхийн төлөө байгаагаа илэрхийлэв.

Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Н.Назарбаев халуун дотно хүлээж авсанд Монголын талд талархал илэрхийлж, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярыг тааламжтай цагтаа Бүгд Найрамдах Казахстан Улсад айлчлахыг урив. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр урилгыг талархан хүлээж авав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр

Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Н.Назарбаев

2008 оны 08 сарын 06